



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 08 сарын 16 өдөр

Дугаар A/44

Улаанбаатар хот

┌ Зочид буудал, дэн буудал, амралтын ┐
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2019” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан, гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Тунамал Алтан Зоос ХХК-ийн “Стар” зочид буудлын 20/347, Эко стар ХХК-ын “Эко стар” зочид буудлын 20/349, Би Ди Би Си Инвест ХХК-ийн “Ану марал” зочид буудлын 20/366, Текко ХХК-ийн “Хаан” зочид буудлын 20/337, Келсо ХХК-ийн “Бест вестерн Гобис Келсо” зочид буудлын 20/18,

Тэтун Хангай ХХК-ийн “Тамир” дэн буудлын 20/78, Ушгар ХХК-ийн “Оюу” дэн буудлын 20/260, Ноён ХХК-ийн “Ноён” амралтын газрын 20/300 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Х.Содномдэмбэрэл/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн Удирдах газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн /Ч.Энх-Отгон/-д үүрэг болгосугай.


7. Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдээс гэрчилгээний үнийн 5,000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Д.Өнөржаргал/-д даалгасугай.

ДАРГА



А.АРИУНГЭРЭЛ

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2021 оны 08
сарын 16-ны өдрийн А/44 дүгээр
тушаалын нэгдүгээр хавсралт



**ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ**

2021 оны 08 дугаар сарын 16-ний өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Вайлд Резорт ХХК	5968615	Тайж Ресорт Хотел	ХУД-ийн, 8-р хороо, Жаргалантын ам
2	Тунамал Алтан Зоос ХХК	5272459	Стар	БГД-ийн, 12-р хороо, Хасбаатарын гудамж 6/1
3	Эко Стар ХХК	5088275	Эко Стар	БГД-ийн, 5-р хороо, ЭТӨЧ-91/4
4	Би Ди Би Си Инвест ХХК	5381738	Ану Марал	БГД-ийн, 9-р хороо, Хасбаатарын гудамж 22
5	Текко ХХК	2595028	Хаан	СБД-ийн, 10-р хороо, 7- р хороолол, Их тойруу 22
6	Келсо ХХК	5673062	Бест вестерн Гобис Келсо	БГД-ийн, 4-р хороо, П.Жасрайн гудамж 27/01
7	Тэтун Хангай ХХК	5493668	Тамир	БЗД-ийн, 10-р хороо, Улаанхуаран 10-р гудамж 252 А

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2021 оны 08
сарын 16-ны өдрийн А/44 дүгээр
тушаалын хоёрдугаар хавсралт

5284325 СБТ-8936 1118263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2021 оны 08 дугаар сарын 16-ний өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Ушгар ХХК	5886783	Оюу	БЗД-ийн, 7-р хороо, 15-р хороолол, 31-113 тоот
2	Жаргал Буман Хишиг ХХК	6636322	Жаргал	СБД-ийн, 11-р хороо, Алтайн 27/110
3	Захгүй мэнэн ХХК	5380073	Мичид	БЗД-ийн, 16-р хороо, Дандарбаатарын гудамж

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2021 оны 08 сарын
16-ны өдрийн А/44 дүгээр
тушаалын гуравдугаар хавсралт

5284325 СБТ-8936 1118263502

АМРАЛТЫН ГАЗАР, ЖУУЛЧНЫ БААЗЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН
НЭГЖИЙН ЖАГСААЛТ

2021 оны 08 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Ганган Ногоон ХХК	6618405	Ганган ногоон	НД-ийн, 6-р хороо, Бумбатын адаг
2	Ноён ХХК	2008386	Ноён Тур	БНД-ийн 5-р хороо, Хэрлэн голын хөвөөнд

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР